Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
нэгдүгээр хавсралт

ТӨВ АЙМГИЙН 2025 ОНЫ ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2026.01.05

Зуунмод

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (ҮХХ)	Үйл ажиллагааны хөтөлбөрийг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийн үнэлгээ хийсэн эсэх		1	0.5	5
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0.5	0.5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	0.5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0.5	0.3	3
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын маягт бөглөсөн байдал	0.5	0.3	3
Хэсгийн оноо				**4**	**3.1**	**31**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал		1	0	0
Хэсгийн оноо				**3**	**2**	**20**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж тайлагнасан байдал		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**8.1**	**81**

__o0o__

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
хоёрдугаар хавсралт

ТӨВ АЙМГИЙН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2026.01.05 Зуунмод

НЭГ.Товч танилцуулга

Аймгийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төрийн захиргааны 7 (*Архивын хэлтэс, Байгаль орчны газар, Орон нутгийн өмчийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Худалдан авах ажиллагааны газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар, Эрүүл мэндийн газар*) байгууллага, 27 сумын Засаг даргын Тамгын газрын "Ёс зүйн дэд хороо"-оос 2025 онд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 93 сургалт, арга хэмжээг зохион байгуулж, нийт 1645 (давхардсан тоогоор) төрийн албан хаагч хамрагджээ.

Нийт 35 байгууллагаас 34 буюу 97.1 хувь нь байгууллагын ёс зүйн дэд хороотой, 1 (Архивын хэлтэс) буюу 2 хувь нь орон тооноос шалтгаалан Ёс зүйн дэд хороо байгуулаагүй байна. 34 байгууллагын Ёс зүйн дэд хороонд 172 (эрэгтэй 27 буюу 15.7%, эмэгтэй 145 буюу 84.3%) албан хаагч ажиллаж байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар 34 байгууллагын Ёс зүйн дэд хороонд 15 гомдол ирсэн бөгөөд 14 гомдол ёс зүйн зөрчилтэй гэж тогтоогдсон байна. Үүнээс ёс зүйн хариуцлага 5 албан хаагчид ногдуулсан. Ёс зүйн хариуцлага ногдуулсан албан тушаалтныг төрийн албаны ангиллаар авч үзвэл ТЗ-3, ТУ-2 байна.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

Аймгийн хэмжээнд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хөтөлбөрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилт 90.1 хувьтай дүгнэгдлээ.

Хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн онцлог ажлаас дурдвал:

1.Төрийн албаны тухай хууль болон төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, бодлого төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт шалгалтын үр дүн, ёс зүй сахилга хариуцлагыг чанаржуулах зорилготой "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" төвийн бүсийн зөвлөгөөнд Төвийн аймгийн төрийн албан хаагчдаа төлөөлж 150 албан хаагч оролцсон. Уг зөвлөгөөнд орон нутгийн албан хаагчид тулгамдаж буй асуудал, санал бодлоо нээлттэй илэрхийлж төрийн албаны шинэтгэлд саналаа тусгуулах боломж бүрдсэн юм.

2.Монгол Улсын Их Хурлын даргын ивээл дор зохион байгуулсан "Төрийн албан хаагчдын үндэсний чуулган"-д Төв аймгаас 31 төлөөлөл оролцлоо.

3.2025 онд Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Баянцагаан, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Бүрэн, Дэлгэрхаан, Мөнгөнморьт, Өндөрширээт, Сэргэлэн, Угтаалцайдам 12 сум "Төрийн албан хаагчийн зөвлөгөөн" зохион байгуулжээ.

4. Монгол Улсын Ёс зүйн хороо, Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан Ёс зүйн сургагч багш бэлтгэх сургалтад 1 төрийн албан хаагч хамрагдсан байна.

5. Тогтвортой хөгжлийн бодлого, үр дүнтэй засаглалын зарчмыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог хангах, сэтгэлгээний өөрчлөлт хийх замаар байгууллагад эерэг соёл төлөвшүүлэх, хөгжлийг хурдасгахад дэмжлэг болох зорилгоор аймгийн ЗДТГ-ын Сургалтын баг "Сэтгэлгээний өөрчлөлт" модуль сургалтыг 4 удаа зохион байгуулж 22 байгууллагын 146 албан хаагч хамрагдлаа.

6.БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга асан, Хөдөлмөрийн баатар, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, төр, нийгмийн зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой түүний ажил, амьдралын намтар, түүх, "Төрийн хүн"-ий зан чанар, сургамжийн талаар аймгийн удирдлага, ИТХ, ЗДТГ, хэлтэс, агентлагийн дарга, мэргэжилтэн 105 алба хаагчид мэдээлэл өгсөн.

2.2 Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал

1. 27 сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, Засаг даргын орлогч, сумын ЗДТГ-ын дарга, Багийн Засаг дарга, сумын ЗДТГ-ын Хууль эрх зүйн мэргэжилтэн, Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Цахим үйлчилгээний мэргэжилтэн зэрэг нийт 305 албан хаагчид "Төрийн албан хаагчийн ёс зүй, манлайлал" сэдвээр сургалт семинарыг зохион байгуулж, мэдээлэл өгсөн.

2. Удирдлагын академиас зохион байгуулсан Төрийн албаны удирдах ажилтны ур чадвар, гүйцэтгэлийн удирдлага сэдэвт сургалтад 2 удирдах албан тушаалтан хамрагдсан байна.

3.Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо, Хүний эрхийн үндэсний комисс, Удирдлагын академиас хамтран зохион байгуулсан "Хүний эрх, ёс зүй" сэдэвт 16 цагийн сургалтад 3 удирдах албан тушаалтныг хамруулаа.

2.3 Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа

34 байгууллагын Ёс зүйн дэд хороо 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, цахим систем оруулж, биелэлтийг тайлагнан ажилласан байна. Ёс зүйн дэд хороодын төлөвлөгөөний биелэлтийн дундаж 92.3 хувьтай хэрэгжсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх 93 сургалт, арга хэмжээ зохион байгуулж 1645 (давхардсан тоогоор) төрийн албан хаагч хамрагдаж, Ёс зүйн зөрчил өмнөх оноос 46.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөн 2025 оны жилийн эцсийн байдлаар 34 байгууллагын Ёс зүйн дэд хороонд 15 гомдол ирсэн бөгөөд 14 гомдолд ёс зүйн зөрчил тогтоогдсон байна. Үүнээс ёс зүйн хариуцлага 5 албан хаагчид ногдуулсан. Ёс зүйн хариуцлага ногдуулсан албан тушаалтныг төрийн албаны ангиллаар авч үзвэл ТЗ-3, ТҮ-2 байна.

Гарсан үр дүн, ололт, амжилт:	**Бэрхшээл**
Тогтвортой хөгжлийн бодлого, үр дүнтэй засаглалын зарчмыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог хангах, сэтгэлгээний өөрчлөлт хийх замаар байгууллагад эерэг соёл төлөвшүүлэх, хөгжлийг хурдасгахад	Ёс зүйн дэд хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын 3.6 дахь хэсэг "Дэд хорооны үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно. Хөндлөнгөөс нөлөөлөх оролдлого гарсан тохиолдолд Дэд хорооны дарга, гишүүн нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг

дэмжлэг болох зорилгоор аймгийн ЗДТГ-ын Сургалтын баг Удирдлагын академийн "Сэтгэлгээний өөрчлөлт" модуль сургалтыг 2025 онд 4 удаа зохион байгуулж 22 байгууллагын 146 албан хаагч хамрагдлаа. Мөн 2024 онд ёс зүйн 28 зөрчил бүртгэгдсэн бол энэ онд 15 болж 46.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу холбогдох байгууллагад мэдэгдэнэ" гэж заасан байдаг нь Дэд хорооны гишүүдэд хөндлөнгийн нөлөөлөл, дарамт, шахалт ирдэг.
Санал:	
Төв аймгийн хэмжээнд Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдэд Ёс зүйн дэд хорооны гишүүнээр ажилласны урамшуулал 2024, 2025 онд олгогдоогүй байна. Ёс зүйн дэд хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын 3.7, 3.8 дахь заалтыг хангуулж ажиллах саналтай байна.	

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

ЗДТГ-ын дарга (С.ЦОГБАЯР)

(албан тушаал) (гарын үсэг) (гарын үсгийн тайлал)

Ёс зүйн дэд хорооны дарга

НБХ-ийн дарга (Д.МӨНХЦЭЦЭГ)

(албан тушаал) (гарын үсэг) (гарын үсгийн тайлал)

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

Хүний нөөцийн сургалт,
хөгжил хариуцсан
мэргэжилтэн (Б.ЦЭРЭНЛХАГВА)

(албан тушаал) (гарын үсэг) (гарын үсгийн тайлал)

2026 оны 01 сарын 5 өдөр

БАТЛАВ:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДЭД
ХОРООНЫ ДАРГА Д.МӨНХЦЭЦЭГ

2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН "ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО"-ЫН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.01.24

Зуунмод

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Төсөв (сая)	Хугацаа (улирал)	Хариуцах эзэн
	Үйл ажиллагааны хүрээнд:			
1	Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж, бүтэн жилээр тооцож үр дүнг тайлагнах	-	II, IV	Б.Цэрэнлхагва
2	Шинээр томилогдсон албан хаагчдад төрийн албаны зарчим, төрийн албан хаагчийн сахин мөрдөх ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг танилцуулж, ёс зүйн амлалтын бичигт гарын үсэг зуруулж, баталгаажуулах • ТЖАХ-ийг тангараг өргөх үед • ТҮАХ-ийг хөдөлмөрийн гэрээ байгуулах үед	ҮА-ны зардал	I	С.Солонго О.Шинэдэдимаа
3	Албан хаагчийн ёс суртахуун, шударга байдлын төлөвшлийг хамт олон, удирдлагаар харилцан үнэлүүлэх, өөрийн үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулж, үр дүнг хамт олонд мэдээллэх	-	II	Т.Хуягбаатар
4	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гомдол, мэдээллийг хууль тогтоомжийн хүрээнд шалгаж, дүгнэлтийг хуулийн хугацаандаа хүргүүлэх	-	I, II, III, IV	Гишүүд тойргийн журмаар
5	Ёс зүйн зөрчлийн шалтгаан, эрсдлийг тодорхойлж, байгууллагын удирдлагад зөвлөмж өгөх	-	I, II, III, IV	Гишүүд тойргийн журмаар
6	Ёс зүйн хариуцлага хүлээсэн албан хаагчийн мэдээллийг ХНУМТ цахим системд бүртгэж, олон нийтэд ил тод мэдээллэх	-	I, II, III, IV	Б.Цэрэнлхагва
	Сургалт, нөлөөллийн ажлын хүрээнд:			
7	Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтад 2-оос доошгүй удаа хамруулах	-	I, II, III, IV	Д.Мөнхцэцэг Г.Мөнхгэрэл
8	Хуульч М.Азбаярын "Төрийн албан хаагчийн ёс зүй, үнэт зүйл, хэм хэмжээ" сургалт	2 сая	II	Д.Мөнхцэцэг Г.Мөнхгэрэл Б.Цэрэнлхагва
9	Шинээр ажилд орсон ажилтанг ЗГХЭГ-ын дэргэдэх Удирдлагын академийн "Ёс зүйн" I, II, III түвшний цахим сургалтад бүрэн хамруулах	-	I, II, III, IV	Б.Цэрэнлхагва
10	Удирдах албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ёс зүйтэй, шударга байдлыг сахин ажиллах, энэ хүрээнд 1-ээс доошгүй			

	нөлөөллийн ажил зохион байгуулах зохицуулалтыг тусгуулж, хэрэгжилтэд хяналт тавих 1. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (II сар) 2. Хууль, эрх зүйн хэлтэс (III сар) 3. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (IV сар) 4. Санхүү, төрийн сангийн хэлтэс (V сар) 5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (VI сар) 6. Нийгмийн бодлогын хэлтэс (VII сар) 7. Цэргийн штаб (IX сар) 8. Үйлчилгээний алба (X сар) 9. Үйлчилгээний нэгдсэн төв (XI сар)	ҮА-ны зардал	I, II, III, IV	Бүх гишүүд

БОЛОВСРУУЛСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД
ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.ЦЭРЭНЛХАГВА